# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Шивээговь сумын Засаг дарга"-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ГСА-2022/03/СТА-ТТ3**

Цахим хуудас: www.audit.mn

Чойр хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер:  Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Аудитор:С.Батцэцэг
Утас:70543179
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. Аудитын гэрчилгээ ..... 3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 13
3. Аудитын тайлан ..... 14
3.1. Ерөнхий зүйл ..... 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 15
3.4 Материаллаг байдал ..... 15
3.5Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт ..... 15
3.5.1 Мөнгөн хөрөнгө ..... 15
3.5.2 Авлага ..... 16
3.5.3 Урьдчилгаа ..... 17
3.5.4 Бараа материал ..... 17
3.5.5 Үндсэн хөрөнгө ..... 17
3.5.6 Өр төлбөр ..... 18
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо ..... 19
3.5.8 Орлогын данс ..... 20
3.5.9 Зардлын данс ..... 20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 20
3.6.1 Төсвийн төлөвлөлт ..... 20
3.6.2 Төсвийн гүйцэтгэл ..... 21
3.6.3 Нэмэлт төсөв ..... 22
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 22
3.8 Аудитын гол асуудал ..... 23
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 23
3.9.1 Шилэн дансны мэдээлэл ..... 23
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... 23
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 23
3.11Дараагийн аудитаар анхаарал асуудал ..... 24
4. Аудитын илрүүлэлт ..... 24
4.1 Харьяа байгууллагууд ..... 24
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч ..... 25
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга ..... 25
4.2.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага ..... 25
4.2.3 Зөвлөмж ..... 25

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| БСУГ | Боловсрол, соёл урлагийн газар |
| БСШУЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ШШГГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |

## 1. Аудитын гэрчилгээ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
П.ГАНЧИМЭГ ТАНАА

2022.03.25 № 54
танай ____________-ны № ____________-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шивээговь сумын “Засаг дарга”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шивээговь сумын “Засаг дарга”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шивээговь сумын “Засаг дарга”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 27,289.1 мянган төгрөгийн дараах алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,934.4 мянган төгрөгөөр их байна.

- Өмнөх онд өгсөн “татварын 7 нэр төрлийн орлого 28.3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан, сумын харьяа байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлагналын алдаа зөрчлийг давтан гаргасан” гэсэн 2 зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлээгүй зөрчил илэрсэн
- Татварын орлого нь нийт дүнгээр биелсэн боловч бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын хураамж, түгээмэл тархацтай АМНАТ, газрын төлбөр, хадгаламжийн хүүгийн орлогууд нэр төрлөөр 27 289.1 мянган төгрөгийг биелээгүй зөрчил илэрсэн

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37, 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.6.3, 15 дугаар зүйлийн 15.4.1, 23 дугаар зүйлийн 23.8.2,

008020201

23.8.8, 23.8.14, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 15 дугаар зүйлийн 15.1, 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалт, УСНББОУС-2, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив"-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3, 1.1.10 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | 794,883.0 | 1,131,367.9 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | 168,115.4 | 159,297.1 |
| **33** | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | 181,288.8 | 402,597.3 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 7а, 7б | 700.0 | 0.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | 413,353.6 | 481,157.9 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 9а | 19,687.2 | 30,976.8 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 10 | 11,738.1 | 57,338.9 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | 4,117,954.6 | 3,678,841.2 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | 4,117,954.6 | 3,678,841.2 |
| **39200** | **Биет хөрөнгө** | | 3,978,412.8 | 3,539,526.0 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 13 | 139,541.8 | 139,315.1 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | 4,912,837.7 | 4,810,209.0 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 14,099.2 | 35,717.1 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | 14,099.2 | 35,717.1 |
| **41300** | **Өглөг** | 17а, 17б | 14,099.2 | 35,717.1 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | 4,898,738.5 | 4,774,491.9 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 4,898,738.5 | 4,774,491.9 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 1,726,858.9 | 1,726,858.9 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | | 1,352,455.1 | 1,228,208.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 1,819,424.5 | 1,819,424.5 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | 4,912,837.7 | 4,810,209.0 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **4,878,768.0** | **4,009,942.8** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | **110,766.8** | **177,536.8** |
| **110** | **Орлогын албан татвар** | | 84,825.2 | 149,655.8 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | | 84,825.2 | 149,655.8 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | | 750.0 | 7,593.4 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | | 25,191.6 | 20,287.6 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1а, 1б | 958,100.4 | 491,208.8 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 958,100.4 | 491,208.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **3,809,900.8** | **3,341,197.3** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2а, 2б** | **4,267,205.3** | **4,144,567.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **4,267,205.3** | **4,144,567.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **3,229,761.5** | **3,985,366.2** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,804,441.4 | 1,922,073.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 224,152.6 | 252,839.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 292,478.7 | 298,510.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 280,310.6 | 269,559.0 |
| 2105 | Нормативт зардал | | 89,115.8 | 322,122.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 18,816.9 | 31,473.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 8,954.6 | 6,835.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 29,902.4 | 12,407.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 481,588.6 | 869,545.7 |
| **212** | **ТАТААС** | | **33,381.3** | **24,392.6** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **1,004,062.5** | **134,808.9** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **0.0** | **0.0** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **611,562.8** | **-134,624.9** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | **0.0** | **0.0** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **17,640.4** | **0.0** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | | **593,922.4** | **-134,624.9** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | | 3,985,545.1 | 3,352,672.5 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | 110,766.8 | 177,536.8 |
| **110** | Орлогын албан татвар | | 84,825.2 | 149,655.8 |
| **1100** | Хувь хүний орлогын албан татвар | | 84,825.2 | 149,655.8 |
| **113** | Хөрөнгийн албан татвар | | 750.0 | 7,593.4 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | | 25,191.6 | 20,287.6 |
| **1180** | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 24,197.4 | 19,881.6 |
| **1181** | Газрын төлбөр | | 994.2 | 406.0 |
| **1183** | Бусад татвар | | 0.0 | 0.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | 60,895.8 | 61,421.9 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | | 60,895.8 | 61,421.9 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 3,813,882.4 | 3,113,713.8 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 3,715,342.8 | 3,036,205.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 3,715,342.8 | 3,036,205.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 2,677,899.0 | 2,845,845.6 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,780,702.3 | 1,900,171.2 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 231,537.6 | 238,399.2 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 290,497.7 | 292,513.1 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | | 72,379.5 | 63,885.0 |
| **2105** | Нормативт зардал | | 75,223.1 | 141,280.7 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | | 39,855.1 | 43,889.7 |
| **2107** | Томилолт, зочны зардал | | 8,954.6 | 6,835.0 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 66,187.3 | 14,285.0 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | | 112,561.8 | 144,586.8 |
| **211** | **ХҮҮ** | | 0.0 | 0.0 |
| **212** | **ТАТААС** | | 33,381.3 | 24,392.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 1,004,062.5 | 165,967.6 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | | 270,202.3 | 316,466.7 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | | 194,267.3 | 325,285.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | 194,267.3 | 325,285.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 194,267.3 | 325,285.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | -194,267.3 | -325,285.0 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | | -89,900.0 | 0.0 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | | 89,900.0 | 0.0 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | -13,965.0 | -8,818.3 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 182,080.4 | 168,115.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 168,115.4 | 159,297.1 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,306,138.9 | 0.0 | 4,306,138.9 |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | -11,341.2 | 0.0 | -11,341.2 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 4,294,797.7 | 0.0 | 4,294,797.7 |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | 10,018.4 | 0.0 | 10,018.4 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 593,922.4 | 0.0 | 593,922.4 |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 4,898,738.5 | 0.0 | 4,898,738.5 |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 4,898,738.5 | 0.0 | 4,898,738.5 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 10,378.3 | 0.0 | 10,378.3 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 4,909,116.8 | 0.0 | 4,909,116.8 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -134,624.9 | 0.0 | -134,624.9 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 4,774,491.9 | 0.0 | 4,774,491.9 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,222,125.80** | **3,113,808.02** | **108,317.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,862,402.80** | **2,827,958.42** | **34,444.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,720,381.40** | **2,685,980.13** | **34,401.27** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,885,861.30** | **1,878,568.47** | **7,292.83** |
| 210101 | Үндсэн цалин | 1,375,235.40 | 1,117,845.28 | 257,390.12 |
| 210102 | Нэмэгдэл | 407,657.90 | 628,485.10 | -220,827.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,698.50 | 13,929.87 | 10,768.63 |
| 210104 | Урамшуулал | 72,833.50 | 116,417.14 | -43,583.64 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,436.00 | 1,891.09 | 3,544.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **232,252.10** | **217,354.33** | **14,897.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 183,226.40 | 171,062.98 | 12,163.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,249.20 | 12,037.40 | 211.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,809.80 | 9,305.60 | 504.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,453.30 | 2,309.50 | 143.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,513.40 | 22,638.85 | 1,874.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **297,981.30** | **292,440,082.23** | **-292,142,100.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 30,600.00 | 29,050.99 | 1,549.01 |
| 210302 | Түлш, халаалт | 228,221.30 | 228,171.00 | 50.30 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 39,160.00 | 35,218.09 | 3,941.91 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 0.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **57,450.50** | **54,950.89** | **2,499.61** |
| 210401 | Бичиг хэрэг | 11,123.90 | 12,736.96 | -1,613.06 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,952.70 | 24,945.95 | 3,006.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,096.70 | 6,763.60 | 1,333.10 |
| 210404 | Ном, хэвлэл | 239.50 | 187.00 | 52.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 662.00 | 642.00 | 20.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,375.70 | 9,675.37 | -299.67 |
| **2105** | **Нормативт зардал** | **58,208.30** | **55,946.40** | **2,261.90** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,003.10 | 11,951.60 | 51.50 |
| 210502 | Хоол, хүнс | 44,461.60 | 42,315.70 | 2,145.90 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,743.60 | 1,679.10 | 64.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **57,971.80** | **57,901.00** | **70.80** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 25,710.00 | 25,640.60 | 69.40 |
| 210602 | Тавилга | 0.00 | 0.00 | 0.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 943.40 | 942.00 | 1.40 |
| 210604 | Урсгал засвар | 31,318.40 | 31,318.40 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,133.20** | **5,675.00** | **458.20** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 | 0.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 6,133.20 | 5,675.00 | 458.20 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0.00 | 0.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **14,846.50** | **14,284.97** | **561.53** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,072.00 | 8,067.69 | 4.31 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000.00 | 2,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,751.50 | 1,600.88 | 150.63 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 917.00 | 863.90 | 53.10 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 256.00 | 176.50 | 79.50 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,720.00 | 1,560.00 | 160.00 |
| 210807 | Газрын төлбөр | 130.00 | 16.00 | 114.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **109,676.40** | **108,858.99** | **817.41** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 105,651.60 | 104,834.19 | 817.41 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,024.80 | 4,024.80 | 0.00 |
| **212** | **ТАТААС** | **24,392.60** | **24,392.60** | **0.00** |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | **24,392.60** | **24,392.60** | **0.00** |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 24,392.60 | 24,392.60 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,628.80** | **117,585,689.26** | **-117,468,060.46** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **10,500.00** | **10,470.80** | **29.20** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 10,500.00 | 10,470.80 | 29.20 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **107,128.80** | **107,114.89** | **13.91** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,418.50 | 41,417.34 | 1.16 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,817.00 | 7,817.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 57,893.30 | 57,880.55 | 12.75 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **316,691.30** | **285,849.60** | **30,841.70** |
| 223001 | Бусад хөрөнгө | 316,691.30 | 285,849.60 | 30,841.70 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **43,031.70** | **0.00** | **43,031.70** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 43,031.70 | 0.00 | 43,031.70 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,222,125.80** | **3,125,691.32** | **96,434.48** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,192,837.60** | **2,192,817.24** | **20.36** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,891,128.00 | 1,891,107.64 | 20.36 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 301,709.60 | 301,709.60 | 0.00 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **892,914.30** | **878,067.49** | **14,846.81** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 892,914.30 | 878,067.49 | 14,846.81 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **27,327.40** | **8,161.89** | **19,165.51** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 27,327.40 | 8,161.89 | 19,165.51 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **109,046.50** | **46,644.70** | **62,401.80** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 26,818.50 | 43,444.69 | -16,626.19 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,981.80 | 3,200.01 | -1,218.21 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 80,246.20 | 0.00 | 80,246.20 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 80,246.22 | -80,246.22 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 92,129.53 | -92,129.53 |

### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **220,359.03** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **220,359.03** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **168,322.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **21,602.71** |
| 210101 | Үндсэн цалин | 21,602.71 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **21,044.85** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,769.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,055.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,318.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 263.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,637.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **73.06** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 73.06 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,009.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 861.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,665.80 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,054.20 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 495.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,932.70 |
| **2105** | **Нормативт зардал** | **85,334.27** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 63,354.26 |
| 210502 | Хоол, хүнс | 19,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,530.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,798.06** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,999.60 |
| 210604 | Урсгал засвар | 10,798.46 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,160.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,160.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,300.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **52,036.99** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **48,411.54** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,411.54 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,625.45** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 3,625.45 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **220,360.13** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **220,360.13** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,149.78 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,328.05 |
| 131106 | Хаагдсан данс | 0.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 147,882.30 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **1.10** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1.10 |

## 3. Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд аудитын дүнг үндэслэн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх, нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх  тухай зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 18-наас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/142 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд хуулийн хугацааг хоцроосон байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Шивээговь сумын Засаг дарга”-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь ““Сумын засаг дарга нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэдээ дээдлэн хөгжлийн бодлого төлөвлөлтөд суурилсан, хариуцлагатай, хурдан шуурхай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх замаар чанарын менежментийн тогтолцоог сайжруулж, Олон Улсын жишигт нийцсэн иргэн төвтэй төрийн үйлчилгээг бий болгоно” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тайланд хугацаанд санхүү албаны дарга 2 удаа солигдсон бөгөөд аудит хийх хугацаанд аудитад шаардлагатай баримт материалыг иж бүрэн ирүүлээгүй, хугацаа хоцроосон, аудитын хугацаанд хамтран ажиллаагүй зэрэг хүндрэл бэрхшээл учирсан.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

“Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 онд харьяа газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3,380.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 33.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 25.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

“Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102.6 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 168.1 сая, эцсийн үлдэгдэл 159.3 сая төгрөг болж, 8.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | - | - | - | - |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 168.1 | 159.3 | -8.8 | 95 |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | - | - | - | - |
| Хадгаламж | - | - | - | - |
| **Дүн** | **168.1** | **159.3** | **-8.8** | **95** |

*Эх сурвалж: “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 159.3 сая төгрөгөөс төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 130.5 сая, ахмадын сангийн дансанд 17.3 сая, барьцаа дансанд 7.9 сая, нэмэлт санхүүжилтийн дансанд 3.6 сая төгрөг байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хадгаламж дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 181.3 сая, эцсийн үлдэгдэл 402.6 сая төгрөг болж, 221.3 сая төгрөгөөр өссөн байна. Авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.2 | 0.1 | 0.1 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 230.5 | 230.5 |
| Татаас, санхүүжилтийн авлага | - | - | - |
| Зээлийн хүүгийн авлага | 8.1 | 8.3 | 0.2 |
| Бусад авлага | 172.9 | 163.7 | -9.2 |
| Зээлийн авлага | - | - | - |
| **Дүн** | **181.3** | **402.6** | **221.3** |

*Эх сурвалж: “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн үндсэн болон зээлийн хүүгийн авлага 8.3 сая, ажиллагчидтай холбогдсон авлага 0.1 сая, сумын эрүүл мэндийн төвийн ковидын санхүүжилтийн авлага 230.5 сая, бусад авлага 163.7 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 130.4 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Шивээговь сумын Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 33 зээлдэгчийн 130.4 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 3 зээлдэгчийн 12.3 сая төгрөгийн авлага хэвийн, 20 зээлдэгчийн 71.4 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 2 зээлдэгчийн 12.5 сая төгрөгийн авлага шүүхэд шилжүүлсэн, 6 зээлдэгчийн 21.8 сая төгрөгийн авлага ШШГГ-т шилжсэн, 2 зээлдэгчийн 12.4 сая төгрөгийн авлага найдваргүй болсон байна.

Эдгээр нь Сум хөгжүүлэх сангийн эргэлтийн хөрөнгө бүрдэхгүй байх, зардлын үр ашиг буурах үр дагавартай байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 0.7 сая, эцсийн үлдэгдэлгүй байна.

*Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 0.7 | 0.0 | -0.7 |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | - | - | - |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | - | - | - |
| Цалингийн урьдчилгаа | - | - | - |
| Томилолтын урьдчилгаа | - | - | - |
| **Дүн** | **0.7** | **0.0** | **-0.7** |

*Эх сурвалж: “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 444.7 сая, эцсийн үлдэгдэл 569.5 сая төгрөг болж 124.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Эм боох материал | 22.0 | 40.2 | 18.2 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 4.5 | 6.9 | 2.4 |
| Бичиг хэргийн материал | 4.9 | 5.9 | 1.0 |
| Аж ахуйн материал | 137.0 | 166.5 | 29.5 |
| Сэлбэг хэрэгсэл | 11.2 | 19.4 | 8.2 |
| Түлш, шатах тослох материал | 5.1 | 1.0 | -4.1 |
| Барилгын засварын материал | 180.7 | 165.8 | -14.9 |
| Хүнсний материал | 3.6 | 10.0 | 6.4 |
| Бусад хангамжийн материал | 26.3 | 47.5 | 21.2 |
| Мал амьтад | 18.0 | 18.0 | - |
| Нөөцийн бараа | 19.7 | 31.0 | 11.3 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 11.7 | 57.3 | 45.6 |
| **Дүн** | **444.7** | **569.5** | **124.8** |

*Эх сурвалж: “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын данс нь худалдан авсан 318.5 сая, иргэд болон ААНБ-ын хандиваар 1.1 сая, шилжүүлэн авсан 1.2 сая, улсын болон орон нутгийн төсөв, харьяа яам, аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 328.0 сая, нийт 648.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 569.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж хасагдсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Бараа материалын тайланд ангилал зөрүүтэй бүртгэсэн хөрөнгөд албан шаардлага хүргүүлсэн / Шивээговь сумын Засаг даргын тамгын газар 189.3 сая, Шивээговь сумын Соёлын төв 2.4, Шивээговь сумын Эрүүл мэндийн төв 24.0 сая /*

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,117.9 сая, эцсийн үлдэгдэл 3,678.8 сая төгрөг болж, 439.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 2,899.4 | 2,529.2 | -370.2 |
| Тээврийн хэрэгсэл | 149.6 | 130.1 | -19.5 |
| Машин тоног төхөөрөмж | 268.4 | 339.2 | 70.8 |
| Тавилга эд хогшил | 145.7 | 143.6 | -2.1 |
| Зам, гүүрний байгууламж | - | 148.8 | 148.8 |
| Түүх соёл, музей дурсгалт зүйлс | 1.7 | 1.7 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 454.6 | 185.1 | -269:5 |
| Номын фонд | 59.1 | 61.7 | 2.6 |
| Программ хангамж | 2.1 | 1.9 | -0.2 |
| Бусад биет бус хөрөнгө | 137.4 | 137.4 | - |
| **Дүн** | **4,117.9** | **3,678.8** | **-439.1** |

*Эх сурвалж: “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 39.4 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 8.8 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 2.2 сая, улсын болон орон нутгийн төсөв, харьяа яам, аймаг сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 204.0 сая, нийт 254.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 0.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Үндсэн хөрөнгөд хяналт тавьж ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгсөн /Шивээговь сумын Засаг даргын тамгын газар, Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Шивээговь сумын Соёлын төв, Шивээговь сумын эрүүл мэндийн төв/*
- *Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын шинжтэй ангилал зөрүүтэй зөрчилд залруулга болон албан шаардлага өгсөн /Шивээговь сумын Засаг даргын тамгын газар 7.5 сая, Шивээговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал 20.0 сая/*
- *Захирамжийн дагуу байгууллагад хөрөнгийн бүртгэл хийгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, хөрөнгийг бүртгээгүй / Шивээговь сумын Засаг даргын тамгын газар 62.3 сая, Шивээговь сумын 3 дугаар сургууль 2.4 сая/*

### 3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 14.1 сая, эцсийн үлдэгдэл 35.7 сая төгрөг болж, 21.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| *Богино хугацаат өр төлбөр дүн* | | | | |
| Ажиллагчидтай холбогдсон өглөг | 0.1 | 18.0 | 17.9 | 100.0 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 9.8 | 9.8 | 100.0 |
| Бусад өглөг | 13.9 | 7.9 | -6.0 | -50.0 |
| *Урт хугацаат өр төлбөр дүн* | - | - | - | - |
| **Нийт дүн** | **14.1** | **35.7** | **21.6** | **100.0** |

*Эх сурвалж: “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 35.7 сая төгрөгийн барьцаа дансны өглөг, ажиллагчидтай холбогдсон өглөг 18.0 сая, бараа үйлчилгээний зардлын өглөг 9.8 сая,

бусад өглөг 7.9 сая, нийт 35.7 сая төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөр тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Завсрын аудитаар 16.2 сая төгрөгийн өр төлбөртэй байсныг залруулсан / Шивээговь сумын ЗДТГ 8.0 сая, Шивээговь сумын Эрүүл мэндийн төв 8.2 сая /*
- *Тайлант онд өр төлбөртэй тайлагнасан / Шивээговь сумын Эрүүл мэндийн төв 27.1 сая, Шивээговь сумын ЗДТГ 0.1 сая, Шивээговь сумын барьцаа данс 7.9 сая /*

### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,898.7 сая, эцсийн үлдэгдэл 4,774.5 сая төгрөг болж, 124.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,726.8 | 1,726.8 | - | - |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | | | |
| Өмч /хувийн/ /ТӨҮГ/ | | | | |
| Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/ | | | | |
| Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/ | | | | |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | | | |
| Хуримтлагдсан үр дүн | 1,352.5 | 1,228.2 | -124.2 | 91.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,819.4 | 1,819.4 | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | | 10.4 | 10.4 | 100 |
| **Дүн** | **4,898.7** | **4,774.5** | **-124.2** | **100** |

*Эх сурвалж: “Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,774.5 сая төгрөг болж 124.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн, бодлогын өөрчлөлт алдааны залруулгаас шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Хувийн өмчийн дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Хувьцааны дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Халаасны хувьцааны дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Нэмж төлөгдсөн капитал дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хуримтлагдсан үр дүн 1,228.2 сая төгрөг болж 124.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн зардал, бодлогын өөрчлөлт алдааны залруулга данснаас шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд нягтлан бодох бүртгэлийн бичилтийн алдааны залруулга хийгдсэнээс шалтгаалж бүртгэгдсэн 159.9 сая төгрөгийн алдааны залруулга байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Засгийн газрын хувь оролцооны данстай холбоотой зөрчил илрээгүй байна.*

### 3.5.8 Орлогын данс

Нэгтгэсэн орлого үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогод ахмадын сангийн орлого 14.8 сая төгрөгийг тайлагнасан байна.

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогод Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого 43.4 сая, туслах үйл ажиллагааны орлогод ахмадын сангийн орлого 14.8 сая, нийт 58.2 сая төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Орлого, үр дүнгийн тайланд СХС-гийн орлогыг 1.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасанд албан шаардлага хүргүүлсэн.*

### 3.5.9 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 140.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон, илүү цагийн хөлсийг илүү тооцож олгосон, тэтгэмж, тусламж олгохдоо ХХОАТ суутгаагүй, томилолтын зардлыг илүү тооцож олгосон, нийт 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон / Шивээговь сумын Эрүүл мэндийн төв 2.1 сая, Шивээговь сумын ЗДТГ 0.7 сая, Шивээговь сумын ИТХ 0.1 сая, Шивээговь сумын 3 дугаар сургууль 0.3 /*
- *Батлагдаагүй орон тоонд хавсран ажилласны нэмэгдэл олгосон, цалингийн зардлаас шагнал урамшуулал олгосон, эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан нийт 6.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн / Шивээговь сумын Эрүүл мэндийн төв 5.8 сая, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг/*
- *Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй нийт 86.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн, алдаа зөрчлийг давтан гаргасан 22.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 64.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж /Шивээговь сумын ОНХС 50.8 сая, Шивээговь сумын 3 дугаар сургууль 9.8 сая, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг 3.4 сая, Шивээговь сумын ЗДТГ 7.9 сая, Шивээговь сумын ИТХ 3.4 сая, Шивээговь сумын Эрүүл мэндийн төв 11.0 сая /*

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийг аймгийн ТЕЗ-аас батлан ирүүлсэн төсвийн хүрээнд сумын ИТХ-аар хэлэлцүүлж сумын төсвийн татварын орлого, тусламжийн орлого, зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг баталдаг байна.

Шивээговь сумын ИТХ-ын 2020 оны 09, 2021 оны 04 дугаар тогтоолоор сумын татварын орлого 154.0 сая, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 692.4 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 301.7 сая, тэнцлийн ашгаас 46.4 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1,964.7 сая, сум хөгжүүлэх сангийн орлого 43.0 сая, ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих 66.0 сая, нийт 3,222.1 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 3,222.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,862.4 сая төгрөгийг урсгал зардалд, 316.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 43.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,964.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 301.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 892.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 61.4 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 66.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,891.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 301.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 892.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 66.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс нийт 3,085.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 46.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 17.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,113.8 сая төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь зардал хэмнэгдэж зарцуулагдсантай холбоотой байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 7.2 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 14.9 сая, тогтмол зардлыг 5.5 сая, хангамж, бараа материалын зардлыг 2.5 сая, нормативд зардлыг 2.3 сая, эд хогшил, урсгал засвар зардлыг 0.07 сая, томилолт зочны зардлыг 0.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр зардлыг 0.6 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.8 сая, урсгал шилжүүлэг зардлыг 0.04 сая, хөрөнгийн зардлыг 30.8 сая, эргэж төлөгдөх зээл зардлыг 43.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 108.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 25 төсөл, арга хэмжээнд 367.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 335.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1.2 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Шивээговь сумын ИТХ-ын сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 04 дугаар тогтоолоор Шивээговь сумын Засаг дарга тайлант онд 154.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 177.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 15 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 9.* Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 7.0 | 16.3 | 9.3 | 100 |
| Хөрөнгө борлуулсны орлого | - | 28.2 | 28.2 | 100 |
| Шууд бус орлого | 76.8 | 83.0 | 6.2 | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бууны албан татвар | 1.6 | 0.5 | **-1.1** | **31.2** |
| Улсын тэмдэгтийн хураамж | 4.5 | 3.3 | -1.2 | 73.3 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 9.0 | 2.0 | **- 7.0** | **22.2** |
| Газрын төлбөр | 2.6 | 0.4 | **-2.2** | **15.4** |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 24.0 | 14.5 | -9.5 | 60.4 |
| Малд ногдуулах албан татвар | 0.0 | 7.0 | 7.0 | 100 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 28.5 | 22.1 | -6.4 | 77 |
| **Нийт дүн** | **154.0** | **177.5** | **23.5** | **68.0** |

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 23.5 сая төгрөгөөр давж биелсэн боловч 4 нэр, төрлийн татварын орлогын төлөвлөгөө биелээгүй байна. Тухайлбал,

Бууны татварын орлого 0.5 сая буюу 31.2%, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2.0 сая буюу 22.2 %, газрын төлбөр 0.4 сая буюу 15.4%, газрын төлбөр 14.5 сая буюу 60.4-иар тус тус тасарсан байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 5.0 сая, “Шивээ-Овоо” ХК-аас 5.0 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 47.1 сая, БСШУЯ-наас 8.4 сая, ЭМЯ-наас 30.4 сая, засаг даргын нөөц хөрөнгөөс 7.2 сая, БСУГ-аас 1.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20.3 мянга, Эрүүл мэндийн төвийн орлого 14.2 сая, номын түрээсийн орлого 3.0 сая, өвс борлуулсны орлого 3.0 сая, Соёлын төвийн орлого 0.03 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 147.9 сая, нийт 220.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 21.6 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардалд 21.0 сая, тогтмол зардалд 0.07 сая, хангамж, бараа материалын зардлыг 9.0 сая, нормативд зардлыг 85.3 сая, эд хогшил, урсгал засвар зардлыг 20.8 сая, томилолт зочны зардлыг 1.1 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 9.3 сая, урсгал шилжүүлэг 48.4 сая, нийт 216.7 сая төгрөгийг зарцуулж, 3.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан ИТХ-ын үйл ажиллагаа, Засаг даргын ажлын алба, багийн засаг даргын үйл ажиллагаа, Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, Ерөнхий боловсролын үйлчилгээ, Соёлын үйлчилгээ, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүрээнд нийт 6 үзүүлэлтийн зорилтот түвшинд 1,070.0 мянган төгрөг баталснаас гүйцэтгэлээр 86.4 хувийн биелэлттэй байна.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Шалгагдагч байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилт 86.4 хувь, батлагдсан төсвийн гүйцэтгэл 96.6 хувьтай байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

### 3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Шивээговь сумын Засаг дарга”-ын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 1793 мэдээлэл байршуулахаас 1693 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийн хугацаа болоогүй, 76 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 128.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 128.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага 4 байгууллагад хүргүүлж, 2 байгууллагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Шивээговь сумын Засаг дарга”-ын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 37.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5.1 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 32.1 сая төгрөгийн давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Төлбөрийн акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 2 | 32.1 | - | - | 2 | 32.1 | 100 |
| **Нийт дүн** | 2 | 32.1 | - | - | 2 | 32.1 | 100 |

## 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАЛ АСУУДАЛ

ТТЗ-аас нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх талаар ажил хийгээгүй байгаа нь алдаа зөрчил гаргах эрсдэлийг нэмэгдүүлж байгаа тул дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 631.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 73.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 558.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчлийн 558.0 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

### 4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 3 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 578.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 47.8 сая төгрөгийн 18 алдааг аудитын явцад залруулж, 3.2 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 108.2 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 291.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн аудитаар 128.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 5.6% буюу 34.5 сая төгрөгөөр буурсан, төлбөрийн акт 78.7% буюу 11.8 сая төгрөгөөр буурсан, албан шаардлага 2 дахин буюу 115.3 сая, зөвлөмж 36% буюу 290.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын 45.8% буюу 128 сая, зөвлөмжийн 14.3% нь Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил байна. /Хавсралт 2-оос үзнэ үү/

### 4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нийт 53.3 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс 26.0 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 27.3 сая төгрөгийн 3 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 27.3 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

#### 4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдсан 26.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж нэгтгээгүй

#### 4.2.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт

Төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт хүргүүлээгүй байна.

#### 4.2.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

- 4.2.2.2 Өмнөх онд өгсөн “татварын 7 нэр төрлийн орлого 28.3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан, сумын харьяа байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлагналын алдаа зөрчлийг давтан гаргасан” гэсэн 2 зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.6.3, 15 дугаар зүйлийн 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 15 дугаар зүйлийн 15.1, 20 дугаар зүйлийн 20.2.10, , дэх заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.2.3.1 Орлогын данстай холбоотой асуудал

*1.1 Илрүүлэлт:*

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч 4 нэр төрлийн татварын орлого 27.3 сая төгрөгөөр тасарсан, хуулиар тогтоосон татварын орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.2, 23.8.8, 23.8.14, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.9 дэх заалтуудыг зөрчсөн, Эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Сумын татварын орлогын төлөвлөгөөг нэр, төрлөөр нь бүрэн биелүүлж ажиллах

#### 4.2.3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

*2.1 Илрүүлэлт:*

Нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх талаар ажил хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37, 15 дугаар зүйлийн 15.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3, 1.1.10 дахь заалтуудыг зөрчсөн, Эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

Санхүүгийн үйл ажиллагаанд хяналтыг сайжруулах мэргэжлийн арга зүйгээр хангах

#### 4.2.3.3 Санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой асуудал

*3.1 Илрүүлэлт:*

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар бэлтгэн гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 15 дугаар зүйлийн 15.4.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.12, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нэгтгэсэн санхүүгийн тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэн гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Аудитын санал дүгнэлт | | | | | | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс | | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт хамруулсан | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Шивээговь сумын Засаг дарга | ГСА-2022/03/СТА-ТТЗ | | | 1 | | | | 5 | 53,294.0 | 1 | 26,005.0 | | | 1 | - | | | 3 | 27,289.1 |
| **ДҮН** | | | | | **1** | | | | **5** | **53,294.0** | **1** | **26,005.0** | | | **1** | **-** | | | **3** | **27,289.1** |

### 5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Шивээговь сумын Засаг дарга | ГСА-2022/03/СТА-ТТЗ | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

Хавсралт 2

**Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл /тайлант он, өмнөх онтой харьцуулсан харьцуулалт/**

| № | Огноо | Зөрчлийн дүн | Шийдвэрлэсэн байдал /Сая төгрөгөөр/ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулсан | Акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| 1 | Тайлант он | 578.7 | 47.8 | 6 | 3.2 | 21 | 236.2 | 14 | 291.5 | |
| 2 | Өмнөх он | 613.1 | 476.0 | 8 | 15.0 | 11 | 120.9 | 9 | 1.2 | |
| **Зөрүү** | | **-34.4** | **-428.2** | **-2** | **-11.8** | **10** | **115.3** | **5** | **290.3** | |